

АКАДЕМИЧ ЙӨНШИӨБҮҮ БЯМБЫН РИНЧЕН ПРОФЕССОР

(ЭШ-ний үйл ажиллагааны тоймоос)

Ц.Шагдарсүрэн

БНМАУ-ын ШУА-ын жинхэнэ гишүүн (1961), профессор Йөншиөбүү Бямбын Ринчен докторын бүтээн туурвисан олон үзүүрт ажилыг ерөнхийд нь нэгэдхэж үзэхүл эрдэмтэн, зохиолч, орчуулагч, сурган хүмүүжүүлэгч, сэтгүүлч гэсэн наад зах нь таван хүний ажил мэргэжлийг нэг биедээ тэгш цогцлуулж, дурдсан салбар бүрээр туурвисан бүтээл нь шинжлэх ухааны нарийн үндэслэлтэй, гярхай ажиглалт, нягт дүгнэлттэй, уншиж танилцсан хэн хүний анхаарал сонирхолыг ямагт татсан байдаг бөлгөө. Энэ удаад дэлхий дахинаа улс монголынхоо нэрийг нэрлүүлсэн их эрдэмтэн, академич Ринчен профессорын судалгаа шинжилгээний ажлынхи нь талаар товчхон өгүүлэхийг чармайсан болно.

Эрдэмтний хувьд академич Ринчен монгол хэл аялгуу, түүх соёл, утга зохиол, ардын билиг хэмээх аман зохиол, угсаатны зүй, бөө судлал, нэр томьёо зэрэг монголын судлалын уламжлалт бараг бүх салбараар эрдэм шинжилгээний ганц сэдэвт зохиол, ном, товхимол, өгүүлэл, тэмдэглэл хэдэн зууг монгол, франц, англи, орос, герман, польш, мажар, чех зэрэг хэлээр бичсэн нь Монголоос гадна БНУАУ, БНПАУ, БНСЧСУ, ЗСБНХУ, БНХАУ, ХБНГУ, Энэдхэг, Финлянд, Франц, Япон, Холланд, АНУ зэрэг улсад хэвлэгдэн гарснаас гадна нэгэнт хэвлэгдэн гарсан ном бүтээлийг нь дам дам авч орчуулан хэвлэсэн удаа цөөнгүй буй.

Дээр дурдсан эрдэм шинжилгээний ажилынхи нь чиглэл дор бүрээ тухайлбал: монгол хэлний судлал гэхэд, авиазүй, үсэгзүй, хэлбэр судлал (буюу үгзүй), өгүүлбэрзүй, түүхэн хэлзүй, найруулга зүй, утга судлал, үгсийн сан, шүлэглэх ёсон гэх зэргээр задран салбарлах бөлгөө.

Тус улсын хэл шинжлэлийн ууган доктор Ринчений эрдэм шинжилгээний зохиол бүтээлийн дотроос хамгийн том нь 1956 онд Унгарын ШУА-д хамгаалж докторын зэрэг хүртсэн *"Монгол бичгийн хэлний зүй"* хэмээх дөрвөн боть нийтдээ 7-8 хэлмэли (буюу дэвтэр) бүтээл юм. Эрдэм шинжилгээний хувьд энэ бүтээл нь монгол хэлний хөгжилийг авиа зүй, үсэг зүй, хэлбэр судлал (буюу үгзүй), өгүүлбэр зүйн төвшинд орчин үеийн хэл шинжлэлийн үүднээс нарийвчлан задлан шинжилсэн анхны суурь зохиол болсон төдийгүй монгол хэлийг уугуул зүй тогтол, онцлогт нь тулгуурлаж судалсан учир, судалгааны арга барилын хувьд ч монгол хэл шинжлэлийн ухаанд шинэ зам мөрийг дурадхан гаргасан бүтээл болсон гэдэгийг онцлон тэмдэглэвэл зохино. Үүний учир гэвэл, монголын уламжлалт хэл шинжлэлд эртний энэтхэгийн хэлшинжлэлийн нөлөө шууд болон төвдөөр дамжин ноёрхож байсан болохоор монгол хэлийг энэтхэг, төвд загвараар судалж байсан ба хожим XIX зуунаас монгол хэлийг судалсан өрнө дахины эрдэмтэн нар мөн л энэдхэг-европ хэлний загварт таацуулан судалсаар байсан нь дам дам уламжилсаар монголын шинэ цагийн гэгдсэн хэл шинжлэлч нар ч монгол хэлээ мөн л энэтхэг-европ хэлний зүйн шаардлагад тохируулан тэр зүгийн хэлэнд ямар ай, аймаг байна, тэр бүхнийг монгол хэлнээс эрэн сурвалжилж, олон зүйл дээр монгол хэлний өвөрмөц онцлогийг хэлзүйн талаас нь бус илэрхийлэх утгын талаас нь дүйх байдлыг оноон тохоож хүчдэн тайлбарласаар ирсэн билээ. Ийм зүйлийн жишээ маш олон бөгөөд давын өмнө монгол үгийг аймаглахуй, тийн ялгал, нэр үгийн тооны онцлог зэргийг дурдахад хангалттай буй заа. Тийм ч учраас 1956 онд докторын зэрэг хамгаалах хурал дээр ном хаялцах албан ёсны шүүмжлэгч нь байсан академич Л.Лигети, доктор Шебеньгьен Ирөөн, Наалди нар *"...монгол хэлийг монгол хэлнийх нь онцлогт тулгуурлаж монгол хэл шинжлэлийн түүхнээ монгол хэлний судлалын шинэ үеийг нээсэн анхны бүтээл болж байна..."* хэмээж уг зохиолыг санал нэгтэй үнэлсэн

байдаг билээ. Тэгээд ч энэхүү шинэ зам мөрийг нь улам дарданшуулсан судлагааны бүтээл буй болж, ахмад үеийн эрдэмтэд ч түрүү түрүүчийнхээ санал дүгнэлтийг эргэн хянасан тохиол ч нэг бус гарчээ.

1960 хэдэн он хүртэл энэхүү суурь бүтээлийн хувьд хэвлэгдэх нөхцөл бүрдээгүй байсаар тэргүүн боть буюу удиртгал, дэд боть буюу авиа зүй, дөтгөөр боть буюу өгүүлбэр зүй нь 1964-67 онд хэвлэгдэн гарсан юм. Харин зор эзэрхэгчийн үеийн хавчилга, атхаг сэтгэлтний балгаар гутгаар боть буюу *монгол хэлний хэлбэр судлал* гэдэг нэртэй дэвтэр 1966 онд хэвлэгдсэн боловч нийтийн хүртээл болж чадаагүй билээ. Бас энэхүү гутгаар дэвтрийн доод хэлмэли буюу монгол хэлний үйл болон сул үгийн хэлбэр судлал, дөтгөөр дэвтрийн доод хэлмэли - өгүүлбэрийн сургаал гэдэг хэсэг хэвлэлийн босгыг ч давах боломж олоогүй юм.

Монгол хэлний нутгийн аялгууны судлалд академич "*Монгол ард улсын хамниган аялгуу*", "*Монгол ард улсын түрэг хэлтэн*", "*Дархад аялгуу*" зэрэг ном бүтээл туурвиснаас гадна санаачилга, удирдлагаар нь "*Монгол ард улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас*"-ын тэргүүн, дэд боть гарч нийтийн хүртээл болсон нь монголын судлалын хүрээнд *Нутагийн аялгууны атлас* зохиохын эхний алхам болсон анхны бүтээл гэж олон эрдэмтэн үнэлсээр байна.

1930-аад оноос эхлэн академич Ринчен багштан насан элтэлээ Улсын нэр томъёоны комиссын гишүүн байсан бөгөөд монгол хэлний шинэ нэр томъёоны анхны хэдэн дэвтэр толь бичгийг латин, орос, монгол хэлээр, үгийн хэлхээний хамт боловсруулан нийтлүүлэх ажлыг гардан хийж байснаас гадна монгол хэлээ цэвэр ариун байлгах, монгол хэлний сонгодог найруулгыг хөгжүүлэн нийтийн хүртээл болгох, улмаар зөв бичих зүйг нарийсган боловсруулах, монгол хэлний шүлгийн тогтолцоо, онцлогийг судлан гаргах зорилго бүхий өдий төдий өгүүлэл, ном товхимол хэвлэн гаргасан нь олон нийтийн хувьд эх хэлний боловсролыг дээшлүүлж, монгол хэлний хөгжлийн зүй тогтлыг зөв үндэстэй ухаж мэдэхэд монгол хэл байсаар л байх нөхцөлд хувь нэмрээ оруулсаар л байх болно. Нэгэн зүйлийг тэмдэглэхэд, монгол хэлний маань учир холбогдлыг үл хайхрагчид улс орны хэлний бодолгыг "залж" байсан учраас монгол хэлийг монгол хэлний онцлогийн үүднээс судалсан цөөн хэдэн эрдэмтний судалгааны үр дүн нийт олны эх хэлний боловсролд зүй зохисоор нөлөөлж чадалгүй өдийг хүрсэн нь нэн харамсалтай.

Академич Ринчен профессорын бас нэгэн гавьяа бол зүдэг хар цагийн эрхээр арга буюу мартагдан үгүй болохоос нь өмнө амжиж тавиад жилийн турш сурвалжлан тэмдэглэж авсан зан заншил, ардын билиг хэмээх аман зохиол, бөөгийн ёсны аман зохиол, мөн бичигийн зохиол хийгээд гар бичмэл ном зэргийг цуглуулан шинжлэх ухааны эргэлтэд оруулсан явдал мөн. Тэгээд ч тэрхүү баян цуглуулгаасаа сорлож ардын билиг, монголын бөө судлалд холбогдох хэрэглэгдэхүүнийг бие даасан 8 боть ном болгож, Биесбаден (Wiesbaden) хотноо хэвлүүлэн гаргасан¹ бөгөөд дараахан нь ардын билгийн таван ботид орсон ховор нандин дурсгал-тууль үлгэрийг монголч эрдэмтэн Н.Поппе англи хэлээр орчуулан хэвлүүлжээ². Бас монголын бөөгийн дуудлагад холбогдох хэрэглэгдэхүүнийг нь францын монголч эрдэмтэн Марие-Доминик Эвэн францаар орчуулан эрдэм шинжилгээний тайлбар сэлттэй нийтлэн гаргажээ³. Энэ бүхнээс үзэхэд академичийн анхаарч, цаг хүч заран цуглуулсан монгол ардын билиг зүйн 9 боть цоморлиг нь судалгаа шинжилгээний ховор чухаг хэрэглэгдэхүүн болохын хажуугаар дэлхийн олон орны монголч эрдэмтний хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх уулзвар болж өгсөн гэж хэлэх үндэс бүрэн байна.

Германид хэвлүүлсэн номынхоо шагналын мөнгөөр номын эхээс зураг татан буулгадаг хэвлэлийн 4 машин худалдан авч Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэрийн хаягаар ирүүлсэн тухай тус үйлдвэрийн даргаар он удаан жил ажилласан Содномсамбуу гуай ярьдаг бөгөөд тэр цагт Ринчен багшитаны талаар нааштай үг яриа олон нийтийн чихэнд хүрэх боломжгүй байсан тул зуурам мартагдахад хүрчээ.


¹ B. Rintchen, *Les matériaux pour l'étude du chamanisme mongol*, I, II, III, - Asiatische Forschungen, Band 3, 8, 40, Wiesbaden, 1959, 1961, 1975; B. Rintchen, *Folklore Mongol*, I, II, III, IV, V, - Asiatische Forschungen, Band 7, 11, 12, 15, 30, Wiesbaden, 1960, 1963, 1964, 1965, 1972.

² N. Poppe, *Mongol Epen*, I, II, - Asiatische Forschungen, Band 42, 43, Wiesbaden, 1975.

³ Marie-Dominique Even, *Chants de chamanes mongoles*, - Etudes mongoles ... et Siberiennes, Cahier 19-20, Paris, 1988/1989.

Үүний зэрэгцээ академич Ринчен тус улсад бөө судлалын эхийг таьж, монгол ардын утга соёл, зан заншилтай холбогдол бүхий олон орны эрдэмтдийн хувьд учир битүүлэг байсан өдий төдий асуудлыг тодорхой баримт сэлтэд тулгуурлаж шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлаж өгсөн нь хүн төрөлхтний хөгжлийн нэн эртний нийтлэг шашин суртал-бөөгийн ёсон, ертөнцийг үзэх үзлийн учир холбогдлыг тайлан ойлгоход чухаг хувь нэмэр болсоор байна.

Номзүй болон зохиол бүтээлийн гарчиг гэдэг зүйл хэдийгээр судлагаа шинжилгээний ажилд үлэмжхэн хэрэгтэй боловч тэр бүр хүн түүнийг ойлгож чухал гэж үздэггүй явдал одоо болтол үргэлжлэсээр байна. Харин Ринчен профессор ХХ зууны хорь гучаад оноос энэ салбарт анхаарч монгол шунхан барын "Ганжуур", "Данжуур"-ын гарчигийг хийж эхлэсэн боловч улс төрийн үнэлгээний учир холбогдолоор тус улсад гарч чадаагүй юм. Цагийн эрхээр "Ганжуур"-ын гарчиг нь гар бичмэлээрээ хэсэг бусаг үлдэж "Данжуур"-ын гарчиг⁴ нь Энэдхэгт хэвлэгдэн эхлэж эхиний гурван боть нь гарчээ.



Академич Ринчен багшийн бүтээлийг уншихад аль нэгэн зүйлийн талаар дурдангаа "...судлах эзэнээ хүлээж буй сэдэв..." хэмээн онцлон тэмдэглэсэн байх нь үлэмж олон бөгөөд зөвхөн үүнийг нь цуглуулан жагсаах бөгөөс профессорын бүтээлийг туулж уншилгүй, монголын судлалаар судлагааны чиглэлээ олж ядан буй хүмүүст даруй чиг зүгээ олоход тус болно гэж санагддаг.

⁴ Rintchen, *Catalogue du Tanjur mongol imprimé*, Part. 1, 2, 3, New Delhi, 1964 (1-186 p.), 1974 (187-432 p.), 1974 (433-739 p.).

Академич Ринчен профессорын эрдэм шинжилгээний олон үзүүрт зохиол бүтээл нь зөвхөн монголын судлалд төдийгүй Алтай судлалын хүрээнд, мөн төв Азийн олон ард түмний утга соёлын харилцааны түүхнээ онцгой ач холбогдолтой байсан юм. Тэгээд ч шинжлэх ухаанд оруулсан гавьяа зүтгэлий нь үнэлж 1958 онд Олон улсын Фин-угорын нийгэмлэг сурвалжлагч гишүүнээр, 1965 онд Олон улсын Алтай судлалын байнгын Бага хурал Алтан медалиараа, 1970 онд БНУАУ-ын ШУА хүндэт гишүүнээрээ, мөн онд БНПАУ Польшийн соёлд гавьяа бүхий зүтгэлтний Тэмдэгээрээ, Польшийн зохиолчдын нөхөрлөл (ЗАИКС) мөнгөн медаль, Хүндэт жуух бичгээрээ тус тус урамшуулан хөхиүлж шагнасан билээ.

Гэвч академичийн эрдэм шинжилгээний цөөн бус бүтээл нь зүдэг харанхуй цагийн атгаг хар санаатны харгайгаар цааз хуулийн ямар нэгэн үндэслэлгүйгээр хаагдаж, зохиол бүтээлээ хэвлүүлэн нийтлүүлэх эрхий нь хассан "аман шийдвэр"-ийн учраас нийтийн хүртээл болж чадаагүй юм. Үүнд: дээр цухас дурдсан "Монгол хэлний бичгийн зүй"-н 3-4 хэлмэли (буюу дэвтэр), "Дархад аялгуу" гэдэг ганц сэдэвт зохиол, "Олон улсын монголч эрдэмтний Их хурлын хэвлэл -Студиа Монголика (Studia mongolica) гэдэг жил тутмын цувралд нийтлүүлэхээр өгсөн боловч хоригдон гараагүй, орос бичгийн хэлний яруу тансаг найруулгаар гайхалтай сайхан бичсэн "Сказатели и сказочники у монголов"⁵ буюу "Үлгэрчийн эрдэм", "Мухар сүсэгийн хүлээс алдарагсад" хэмээх намтар тууж⁶, "Эмгэн сойвон"⁷ хэмээх түүхэн туурь, "Налина", "Бэр цэцэг" гэдэг бүжигийн жүжигийн хоёр цомнол⁸, хэдэн араваар тоолох шүлэг зэрэг том жижиг олон бүтээлийг дурдаж болно.

Эрдэм шинжилгээний ажлын хажуугаар шинжлэх ухааны ажлыг зохион байгуулах, шинэ залуу хүчинийг бэлэдхэн өсгөх, монголын судлалын олон салбарыг дэлхий дахинаа хөгжүүлэн бэхжүүлэхэд академичийн гаргасан зүтгэл санаачилгыг дурдалгүй орхиж хэрхэвч болохгүй буй заа.

Түүний зүтгэл санаачилгаар 1950 хэдэн оны сүүлчээс Хэл зохиол судлах газараас цэвэр эрдэм шинжилгээний чиглэл бүхий "Монголын судлал", "Аман зохиолын судлал", "Дурсгалт бичгийн чуулган", эрдэм шинжилгээ-сурталчилгааны "Хэл зохиол судлал" гэдэг цуврал бичиг жил тутам хэвлэгдэх болж холбогдох чиглэлээрээ зөвхөн монгол төдийгүй дэлхийн олон орны монголч эрдэмтний зохиол бүтээлийг хэвлэн нийтлэх, монгол ардынхаа утга соёлын ховор нандин дурсгал эх бичгийг олон нийтэд хүртээл болгох индэр болсоор өнөөдрийг хүрчээ. 1961 онд Шинжлэх Ухааны Академи байгуулагдахын өмнө буюу 1950-иад оны сүүл 1960-аад оны эхээр Шинжлэх ухааны хүрээлэн нэрийн хувьд үгүй болж үйл ажиллагаа бүтэцийн хувьд Шинжлэх ухаан дээд боловсролын хороо (хүрээлэн)-д харъяалагдаж байсан бөгөөд энэ үед Олон Улсын монгол хэлбичигийн эрдэмтний анхдугаар хуралын бэлтгэл болгож хэл зохиолын салбараар дээр дурдсан цуврал бичигийн хажуугаар түүхийн салбараар гарч эхлэсэн "Түүхийн судлал", "Монголын түүхийн дурсгалт бичигийн чуулган" зэрэг цувралууд буй болоход тухайн үеийн Шинжлэх Ухаан Дээд боловсролын хороо гэж байхад Салбарын захирал байсан академич Ринчений санаачилга багагүй байсаныг тэмдэглэх хэрэгтэй юм.

1959 онд Олон улсын монгол хэл бичигийн эрдэмтний анхдугаар их хурлыг санаачилан зохион байгуулах, бэлэдхэх ажилд их үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ хурал нь дэлхийн олон орны монголч эрдэмтний үйл ажиллагаа болон хүчин зүтгэлийг нэгтгэн өгч олон улсын монголын судлалд цоо шинэ үе шатыг нээсэн билээ.

Эрдмийн шим хүртээгч багшийн хувьд Ринчен профессор МУИС-д монгол хэл бичигийн анхны тэнхимийн эрхилэгч, багшаар олон жил ажиллаж монгол хэл зохиолын мэрэгшилд боловсон хүчний хэдэн үеийг бэлтгэлцсэнээс гадна олон салбараар ажиллаа гэж гоочлуулсаар

⁵ Үгүй болохын даваан дээр очсон энэхүү бүтээлийг нь доктор Б. Сумъяабаатар 2002 нд *Чингисийн алтан урагийн угийн бичиг ба гэрийн үеийн бичмэл* (Тэргүүн дэвтэр) номдоо уг эхээр нь оруулж шавийн хувьд ёслол журамыг гүйцэтгэсэнд гүнээ талархаж байна.

⁶ Энэхүү томоохон намтар тууж нь ШУА-аас үүсхэн гаргаж буй "Монголын шинжлэх ухаан" хэмээх 108 боть цувралын 5-р ботиор гарсан, Ц. Шагдарсүрэн, О. Адъяа нарын эмхидхэсэн "Бямбын Ринчен" (Улаанбаатар, 2004) гэдэг номд анх удаа хэвлэгдсэн болно.

⁷ 1993 онд "Хотол чуулган" сэтгүүлийн эхний дугаарт Ц. Шагдарсүрэн товч тайлбар бичиж "Эмгэн сойвон" хэмээх түүхэн туурийг анх нийтлүүлжээ.

⁸ Энэхүү хоёр цомнол дээр дурдсан Ц. Шагдарсүрэн, О. Адъяа нарын эмхидхэсэн "Бямбын Ринчен" (Улаанбаатар, 2004) гэдэг номд хэвлэгдсэн болно.

байсан эрдэм судлалынхаа нөр их ажлын зэрэгцээ хэл шинжлэл, утга зохиол, угсаатны зүй, ардын билиг, утга соёл, эдийн боловсрол, бичвэр судлал, урлаг судлал, орчуулах ёсон, бөө судлал гэх зэрэг салбараар эрдэм шинжилгээний авьяаслаг олон залуу ажилтныг дагалдуулан, эрдмийн зам мөрий нь удирдаж, нарийн мэргэшсэн эрдэмтэн мэргэжилтнийг бэлтгэж өгсөн нь түүний бас нэг гавьяа мөн.

Үүний дээр нийгэмийн аж амьдрал, түүний дотор хэл соёлын харилцааг олон улсын болон үндэсний, түүнчилэн салбарын хуульзүйн аргаар зохицуулах талаар эртнээс анхаарч ирсэнийг хэлэх хэрэгтэй. Тухайлан өгүүлэхэд, НҮБ-аас 1948 оны арванхоёрдугаар сарын 10-нд батлан гаргасан "Хүний эрх мэдлийн ер нийт тунхаг"-ийг тухайн үед нь монголчлож, "Соёлын дурсгалт зүйлийг сахин хамгаалах хууль"-ийн төсөл санаачилан боловсруулж байсан нь одоо гар бичмэлээрээ хадгалагдан иржээ. Энэ бүхэн бол улс орны хөгжилийг дэлхийн жишигээр харж байсаны нутлагаа юм.

Эрдэм судлагааны хувьд үлэмж өргөн хүрээтэй, гүнзгий дүн шинжилгээ бүхий академич Ринчен багшитаны бүтээл туурвилын талаар бичнэ гэдэг нь нэг бодоход миний чадалаас хэтийдсэн хэрэг боловч үүнээс өмнө олон салбараар хийсэн бүтээлийнхи нь талаар хүмүүсийн бичсэн зүйл, дурсамж дурадхал цөөн бус тул түүнээс нөхөн үзэх бас нэгэн боломж байна гэж сэтгэлээ засав. Ер нь ийм том эрдэмтэний судлагааны үйл ажиллагааг чиглэл бүрээр нь, тухайн нэг чиглэл гэхэд цааш нь нарийсган салбарлуулалгүй авч үзэх аргагүй бөгөөд хэрэвээ тэгж гэмээ нь салбар бүрээр нарийн мэргэшсэн хэдэн арван хүний оролцоо зайлашгүй шаардалгатай болно.

Ийнхүү Монголын ард түмэн, дэлхийн олон орны монголч эрдэмтэн мэргэд, эрдэм шинжилгээний байгууллагын хайр хүндэтгэлийг зүй ёсоор хүлээсэн, журамт эрдэмтэн академич, профессор Йеншиөбүү Бямбын Ринчен доктор амьдралын цагаан барааныг бие сэтгэлийнхээ тэнхээгээр хатамжилан давж 72 наслахдаа монголынхоо ард түмний эх хэл, бичиг ном, түүх соёлын гайхамшигт их сан хөмрөгийг хамгаалан судлах буянтай үйлсэд нэгэн үзүүрт сэтгэлийг батад барьж бүтээн туурвисаар ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн боловч зохиол бүтээл нь олон түмний боловсрол, эрдэмийн савыг тэтгэсээр гэгээн дүр, шударгуу зан нь хүмүүсийн сэтгэл зүрхнээ янзаараа байсаар байна. Тэгээд ч ийнхүү академичийн эснэсэний нь 100 жилийн ойг тэмдэглэн буй зөвхөн энэ 2005 онд дотоод гадаадад тусхайлан зориулж нийтлэгдсэн ном энэ хэр тавд хүрчээ.

Тэмдэглэх нэгэн зүйл: Академичийн хэвлэгдэн нийтлэгдсэн бүтээлийг холбогдох гар бичмэл эхтэй нь харьцуулан үзэхэд нэлээд зөрөө ялгаа харагддаг. Зарим нь тухайн зүйлийг улам боловсронгуй болгож зассан байх боловч цаг үеийн учир шалтгаанаас үүдэж хассан танасан зүйл ч багагүй буй (Хавсралтаас үзмүү!). Иймд манайхины яриад байгаа боловч төдий л ахицтай бус байгаа **Ринчин судлал**-ын хүрээнд академичийн гар бичмэлийг эрдэм шинжилгээ болон уран зохиол, харилцсан захидал гэх мэтээр салбар салбараар нь судлах ажил зайлашгүй гарч ирнэ гэдэгт бүрэнээ итгэж байна.

Ном эрдэнэ арвитах болтугай.

2005 оны 11-р сарын 26.

